

### Техникийн ажлын хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн “б”, 29.2, Засгийн газрын 2018 оны 43 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2015 оны 05 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан зээлийн хэлэлцээр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн хөгжлийн банк хооронд 2015 оны 05 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан төслийн гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэрэгжүүлж буй “Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр- төсөл 1”-ийн хэрэгжилтийн хэвийн үйл ажиллагааг хангаж, эрчимжүүлэх зорилгоор техникийн болон нийтийн тээврийн бодлогын зарим асуудлуудыг хэлэлцэх, шуурхай удирдлагаар хангах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад тулгарч болзошгүй техникийн зохицуулалтын шийдлийг гаргах, шаардлагатай стандартуудыг батлуулах асуудлаар Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран ажиллах үүрэг бүхий Техникийн ажлын хороог хавсралт ёсоор байгуулсугай.

2. Нийтийн тээврийн техникийн ажлын хорооны үйл ажиллагааг яаралтай эхлүүлэн, шуурхай зохион байгуулах, улирал тутам /шаардлагатай тохиолдолд ээлжит бусаар хуралдах/ хуралдаж, холбогдох мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажиллахыг Техникийн ажлын хороо /П.Баярхүү/-нд үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД

## ТЕХНИКИЙН АЖЛЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Ахлагч -Нийслэлийн Засаг даргын дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч
- Гишүүд: -Улаанбаатар хотын Ерөнхий архитектор бөгөөд Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын дарга;
- Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын дарга;
- Нийслэлийн Газрын албаны дарга;
- Нийслэлийн Тээврийн газрын орлогч дарга;
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга;
- Нийслэлийн Мэдээлэл технологийн газрын Мэдээллийн сүлжээ, техник, хяналтын хэлтсийн дарга;
- “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨҮГ-ын Хөдөлгөөн зохицуулалт, хяналтын хэлтсийн дарга;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Авто зам, тээвэр, ложистикийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн;
- Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын ахлах мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/;
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Цэвэр технологи, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/;
- Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/;
- Барилга, хот байгуулалтын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/;
- Цагдаагийн Ерөнхий газрын Замын цагдаагийн албаны Техник, замын хяналтын хэлтсийн чиглэлийн ахлах мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/;

-“Улаанбаатар дулааны сүлжээ” ХК-ийн төлөөлөл  
/зөвшилцсөнөөр/;

-Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын мэргэжилтэн  
/зөвшилцсөнөөр/;

-“Ус сувгийн удирдах газар” ОНӨҮГ-ын Инженерийн бодлогын  
хэлтсийн инженер.

Нарийн бичгийн дарга “Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын  
хөтөлбөр-төсөл 1”-ийн зохицуулагч.